



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 17/587

Есөнбулаг

Хүүхдийн ардын урлаг, соёлын
"Алтайн алтан өв" наадмын ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн ардын урлаг, соёлын "Алтайн алтан өв" наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Наадмын удирдамж, төсвийг батлуулан үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг ажлын хэсэг (Засаг даргын орлогч)-т, наадамд оролцогчдод дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг сумын Засаг дарга нарт, оролцогч хүүхдүүдийн аюулгүй байдал, авто тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж, оролцуулахыг ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад, наадмын үеэр гэмт хэрэг, хэв журмын зөрчил гарахаас урьдчилан сэргийлж ажиллахыг Цагдаагийн газарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын
20²⁴ оны 09 дүгээр сарын 09 -ны
өдрийн 457 дугаар захирамжийн
хавсралт

ХҮҮХДИЙН АРДЫН УРЛАГ, СОЁЛЫН "АЛТАЙН АЛТАН ӨВ"
НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын Нийгмийн бодлого
хариуцсан орлогч
- Гишүүд: Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга
Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын
газрын дарга
Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын
дарга
Цагдаагийн газрын дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Аймгийн Боловсролын газрын дарга
Ардын дуу бүжгийн "Алтай" чуулга"-ын дарга
Биеийн тамир, спортын газрын дарга
Сумдын Засаг дарга нар
- Нарийн бичгийн дарга: Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын
газрын Соёл урлагийн хэлтсийн дарга
Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын
Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан
мэргэжилтэн